



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/220/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261740 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn
Аудитор: Ц.Цэрэнхүү
Утас: 261740 Цахим хаяг: tserenkhuits@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Төлбөрийн акт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/396

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	495,855,481.55	365,985,388.00
33	АВЛАГА	1,539,695.60	-
33500	Бусад авлага	1,539,695.60	-
33510	Байгууллагаас авах авлага	1,539,695.60	-
35	БАРАА МАТЕРИАЛ	494,315,785.95	365,985,388.00
35400	Хангамжийн материал	494,315,785.95	365,985,388.00
35410	Бичиг хэргийн материал	5,446,820.00	24,536,600.00
35420	Аж ахуйн материал	475,573,372.95	341,448,788.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,381,400.00	-
35440	Түлш, шатах тослох материал	6,914,193.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,767,944,129.86	1,291,400,614.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,767,944,129.86	1,291,400,614.17
39200	Биет хөрөнгө	583,850,700.86	340,024,792.87
39203	Авто-тээврийн хэрэгсэл	579,304,720.00	579,304,720.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(579,304,720.00)	(579,304,720.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	490,241,847.00	490,241,847.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(107,402,331.20)	(265,673,243.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	398,754,195.70	398,754,195.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(199,477,510.64)	(285,032,506.49)
39217	Ном	1,734,500.00	1,734,500.00
39300	Биет бус хөрөнгө	1,184,093,429.00	951,375,821.30
39303	Бусад биет бус хөрөнгө	1,488,065,523.57	1,488,065,523.57
39304	Хуримтлагдсан элэгдэл	(303,972,094.57)	(536,689,702.27)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,263,799,611.41	1,657,386,002.17
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	37,713,165.00	10.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	37,713,165.00	10.00
41300	Өглөг	37,713,165.00	10.00
41360	Бусад өглөг	37,713,165.00	10.00
41361	Байгууллагад төлөх өглөг	37,713,165.00	10.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,226,086,446.41	1,657,385,992.17
51	Засгийн газрын хувь оролцоо	2,226,086,446.41	1,657,385,992.17
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	304,117,253.38	304,117,253.38
51200	Хуримтлагдсан үр дүн	1,921,969,193.03	1,353,268,738.79
51210	Өмнөх үеийн үр дүн	2,046,179,792.43	1,921,969,193.03
51220	Тайлант үеийн үр дүн	(124,210,599.40)	(568,700,454.24)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,263,799,611.41	1,657,386,002.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,103,538,854.00	4,588,403,087.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	147,000,054.00	44,787.00
120	Нийтлэг татварын бус орлого	147,000,054.00	44,787.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	774,414.00	0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	774,414.00	44,787.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	146,225,640.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,956,538,800.00	4,588,358,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,956,538,800.00	4,588,358,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,956,538,800.00	4,588,358,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,215,071,220.52	5,157,103,541.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,215,071,220.52	5,157,103,541.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,898,084,646.01	4,743,540,555.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,355,744,703.31	2,141,256,863.21
210101	Үндсэн цалин	1,316,291,483.31	1,151,612,460.71
210102	Нэмэгдэл	575,143,320.00	596,489,039.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	170,090,000.00	194,022,454.70
210104	Урамшуулал	294,219,900.00	199,132,908.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,356,300.00	325,388,004.34
210201	Тэтгэврийн даатгал	229,658,100.00	224,538,486.91
210202	Тэтгэмжийн даатгал	24,174,500.00	26,890,704.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,339,700.00	16,446,878.63
210204	Ажилгүйдлийн даатгал	4,834,900.00	8,127,299.73
210205	Эрүүл мэндийн даатгал	48,349,100.00	49,384,634.52
2104	Хангамж, бараа материалын зардал	225,507,390.52	288,835,959.03
210401	Бичиг хэрэг	39,708,520.00	31,181,869.00
210402	Тээвэр, шатахуун	24,216,868.00	21,986,780.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,580,193.52	27,131,244.08
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	134,001,809.00	208,536,065.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	71,112,910.00	142,038,997.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	30,133,790.00	70,160,800.00
210604	Урсгал засвар	40,979,120.00	71,878,197.00
2107	Томилолт, зочны зардал	88,313,619.00	58,456,193.60
210701	Гадаад албан томилолт	0	0
210702	Дотоод албан томилолт	88,313,619.00	58,456,193.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,383,441,365.67	1,123,805,204.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,365,005,551.67	1,105,466,142.90
210803	Даатгалын үйлчилгээ	7,375,680.00	6,379,980.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	692,234.00	685,392.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	299,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,068,900.00	11,185,690.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	447,608,357.51	663,759,333.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	139,806,127.25	179,055,818.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	8,160,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	307,802,230.26	476,543,515.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	316,986,574.51	413,562,985.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,934,841.00	224,643,751.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,420,823.00	36,646,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0	124,275,000.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	65,614,018.00	55,910,551.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,900,000.00	7,812,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	222,051,733.51	188,919,234.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	222,051,733.51	188,919,234.47
213304	Хөрөнгийн	0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-111,532,366.52	-568,700,454.24
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	12,678,232.88	0
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	11,903,818.88	0
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	774,414.00	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-124,210,599.40	-568,700,454.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,956,538,800.00	4,588,358,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,956,538,800.00	4,588,358,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,956,538,800.00	4,588,358,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,956,538,800.00	4,588,358,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,786,779,837.00	4,588,358,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,786,779,837.00	4,588,358,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,469,793,262.49	4,174,795,314.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,356,496,178.97	2,141,242,883.32
210101	Үндсэн цалин	1,317,061,078.97	1,150,275,129.95
210102	Нэмэгдэл	575,125,200.00	597,728,391.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	170,090,000.00	194,106,454.30
210104	Урамшуулал	294,219,900.00	199,132,908.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,356,300.00	324,335,828.27
210201	Тэтгэврийн даатгал	229,658,100.00	222,205,589.47
210202	Тэтгэмжийн даатгал	24,174,500.00	24,789,813.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,339,700.00	19,828,490.91
210204	Ажилгүйдлийн даатгал	4,834,900.00	8,127,299.73
210205	Эрүүл мэндийн даатгал	48,349,100.00	49,384,634.52
2104	Хангамж, бараа материалын зардал	122,073,432.52	81,675,870.08
210401	Бичиг хэрэг	33,044,300.00	24,137,100.00
210402	Тээвэр, шатахуун	28,080,000.00	15,227,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,691,063.52	22,224,234.08
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,258,069.00	20,086,736.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	233,302,530.00	87,216,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,850,000.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	185,781,410.00	72,416,200.00
210604	Урсгал засвар	43,671,120.00	14,800,000.00
2107	Томиллолт, зочны зардал	87,877,713.00	57,472,668.60
210702	Дотоод албан томиллолт	87,877,713.00	57,472,668.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,165,214,929.00	1,255,123,260.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,096,353,115.00	1,161,682,888.26
210803	Даатгалын үйлчилгээ	7,375,680.00	6,379,980.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	692,234.00	685,392.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	349,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	60,444,900.00	86,287,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	178,472,179.00	227,728,604.00

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	178,472,179.00	216,568,604.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	11,160,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	316,986,574.51	413,562,985.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,934,841.00	224,643,751.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	21,420,823.00	36,646,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0	124,275,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	65,614,018.00	55,910,551.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,900,000.00	7,812,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	222,051,733.51	188,919,234.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	222,051,733.51	188,919,234.47
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	169,758,963.00	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	169,758,963.00	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	169,758,963.00	0
2200	Дотоод эх үүсвэрээр	169,758,963.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	169,758,963.00	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-169,758,963.00	0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,117,253.38	2,046,179,792.43	2,350,297,045.81
2	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
3	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
4	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
5	Тайлант үеийн үр дүн	0	-124,210,599.40	-124,210,599.40
6	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	304,117,253.38	1,921,969,193.03	2,226,086,446.41
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	304,117,253.38	1,921,969,193.03	2,226,086,446.41
9	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0
10	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0
11	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0
12	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0
13	Зарласан ногдол ашиг	0	0	0
14	Тайлант үеийн үр дүн	0	-568,700,454.24	-568,700,454.24
15	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	304,117,253.38	1,353,268,738.79	1,657,385,992.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэлийн	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,588,358,300.00	4,399,439,065.53	188,919,234.47	95.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,588,358,300.00	4,399,439,065.53	188,919,234.47	95.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,349,281,100.00	4,174,795,314.53	174,485,785.47	96.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,277,454,600.00	2,141,242,883.32	136,211,716.68	94.0
210101	Үндсэн цалин	1,246,246,200.00	1,150,275,129.95	95,971,070.05	92.3
210102	Нэмэгдэл	706,898,500.00	597,728,391.00	109,170,109.00	84.6
210103	Унаа хоолны хөнгөлөлт	170,090,000.00	194,106,454.30	-24,016,454.30	114.1
210104	Урамшуулал	154,219,900.00	199,132,908.07	-44,913,008.07	129.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	326,356,300.00	324,335,828.27	2,020,471.73	99.4
210201	Тэтгэврийн даатгал	229,658,200.00	222,205,589.47	7,452,610.53	96.8
210202	Тэтгэмжийн даатгал	24,174,500.00	24,789,813.64	-615,313.64	102.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,339,600.00	19,828,490.91	-488,890.91	102.5
210204	Ажилгүйдлийн даатгал	4,834,900.00	8,127,299.73	-3,292,399.73	168.1
210205	Эрүүл мэндийн даатгал	48,349,100.00	49,384,634.52	-1,035,534.52	102.1
2104	Хангамж, бараа материалын зардал	81,948,100.00	81,675,870.08	272,229.92	99.7
210401	Бичиг хэрэг	24,137,100.00	24,137,100.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	15,227,800.00	15,227,800.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,788,200.00	22,224,234.08	-1,436,034.08	106.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,795,000.00	20,086,736.00	1,708,264.00	92.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,040,000.00	87,216,200.00	823,800.00	99.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	73,240,000.00	72,416,200.00	823,800.00	98.9
210604	Урсгал засвар	14,800,000.00	14,800,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	64,274,200.00	57,472,668.60	6,801,531.40	89.4
210702	Дотоод албан томилолт	64,274,200.00	57,472,668.60	6,801,531.40	89.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,283,285,700.00	1,255,123,260.26	28,162,439.74	97.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,189,298,700.00	1,161,682,888.26	27,615,811.74	97.7
210803	Даатгалын үйлчилгээ	6,384,000.00	6,379,980.00	4,020.00	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	966,000.00	685,392.00	280,608.00	71.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	350,000.00	88,000.00	262,000.00	25.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	86,287,000.00	86,287,000.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	227,922,200.00	227,728,604.00	193,596.00	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	216,762,200.00	216,568,604.00	193,596.00	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,160,000.00	11,160,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	239,077,200.00	224,643,751.00	14,433,449.00	94.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	239,077,200.00	224,643,751.00	14,433,449.00	94.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	36,646,200.00	36,646,200.00	0.00	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	126,000,000.00	124,275,000.00	1,725,000.00	98.6

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	68,619,000.00	55,910,551.00	12,708,449.00	81.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,812,000.00	7,812,000.00	0.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,588,358,300.00	4,399,439,065.53	188,919,234.47	95.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,588,358,300.00	4,399,439,065.53	188,919,234.47	95.9
310001	Улсын төсвөөс санхүүжих	4,588,358,300.00	4,399,439,065.53	188,919,234.47	95.9
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	78	78	0	100.0
620001	Удирдах ажилтан	15	15	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	60	60	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	3	3	0	100.0
620004	Гэрээт ажилтан	0	0	0	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	78	78	0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	69	69	0	100.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	0	0	0	
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	4	4	0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3	0	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	0	100.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад ажиллагсад урамшуулал олгохдоо хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр олгож байх, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2 дугаар сарын 23-ны хооронд Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитор Ц.Цэрэнхүү нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03/194 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг Засгийн газрын 2020 оны 105 дугаар тогтоолоор баталсан. Үүнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхэм зорилго нь ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлэхэд оршино гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаал “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Уул, уурхай хүнд үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар 16-ны өдрийн А/22 тоот тушаалаар “Дотоод аудитын төлөвлөгөө”-г 5 ажил гүйцэтгэхээр баталж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 34 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөн,

гүйцэтгэлийг тайлагнасан байна. Үүнээс Уул, уурхай хүнд үйлдвэрийн яамны санхүүгийн болон үйл ажиллагаатай холбоотой дараах хяналтыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Архив, албан бичиг хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэсэн;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2020 оны жилийн эцэс, 2021 оны 1, 2, 3 дугаар улирлыг хамруулан шалгаж, тайланг Сангийн яаманд цахимаар хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,215,071.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 52,150.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 606,413.61 мянган төгрөгөөр буюу 26.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

мянган төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Авлага	1,539.7	0.0	-1,539.7
Бараа материал	494,315.8	365,985.4	-128,330.4
Үндсэн хөрөнгө	1,767,944.1	1,291,400.6	-476,543.5
Нийт хөрөнгийн дүн	2,263,799.6	1,657,386.0	-606,413.6
Өр төлбөр	37,713.2	0.0	-37,713.2
Засгийн газрын оруулсан капитал	304,117.3	304,117.3	0.0
Хуримтлагдсан үр дүн	1,921,969.2	1,353,268.7	-568,700.5
Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,263,799.6	1,657,386.0	-606,413.6

Дансны үлдэгдэлд дараах материаллаг хэмжээний өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Өмнөх онд илүү шилжүүлсэн 1,539.7 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг тооцоо нийлж барагдуулсан;
- Ашиглалтгүй болсон, эвдэрч гэмтсэн 349,054.8 мянган төгрөгийн хангамжийн материал, үнэлгээ, судалгааны ажлын тайлан зэргийг Төсвийн шууд захирагчийн 2021 оны А/112 дугаар тушаалын дагуу акталж, данснаас хассан;
- Өр төлбөр данс өмнөх онд үүссэн дотоод ажлын хэрэгцээнд зориулсан цахим систем нэвтрүүлэх ажлын 4,145.5 мянга, газрын тос, уламжлалт бус газрын тосны нөөцийн тооцооны тайлангийн ажлын 33,567.7 мянга, нийт 37,713.12 мянган төгрөгийн өглөгийг барагдуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь 2021 онд 7,961,437.5 мянган төгрөгийн урсгал зардал гаргахаар төлөвлөн төсвийн төслийг хүргүүлж, 5,035,381.0 мянган төгрөгөөр хянагдан батлагдсан. Тайлант онд 1 удаагийн төсвийн тодотгол, 2 удаагийн төсвийн зохицуулалт хийгдэж, анх батлагдсан төсөв нийт 447,022.7 мянган төгрөгөөр бууруулж, 4,588,358.3 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,588,358.3 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 4,399,439.1 мянган төгрөгийг зарцуулж 188,919.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,399,439.1 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь цалин, нэмэгдэл, урамшууллын зардлыг 136,211.7 мянга, албан томилолтын зардлыг 6,801.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 28,162.4 мянга, урсгал шилжүүлгийн зардлыг 14,433.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
1	70905	Олборлолт, уул уурхай	4,588,358.3	4,399,439.1	188,919.2	95.9
1.1	80101	Урсгал санхүүжилт	3,586,615.3	3,439,635.1	146,980.2	95.9
1.2	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	62,296.0	62,289.4	6.6	100.0
1.3	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	118,700.0	116,625.8	2,074.2	98.3
1.4	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	400,098.7	399,975.2	123.5	100.0
1.5	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	126,000.0	124,275.0	1,725.0	98.6
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	113,077.2	100,368.8	12,708.4	81.5
1.7	82401	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	181,571.1	156,269.8	25,301.3	86.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Уул, уурхай хүнд үйлдвэрийн яам нь Төрийн сангийн 100900018403 тоот нэмэлт санхүүжилтийн данс эзэмшдэг бөгөөд тайлант хугацаанд ажил, гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Уул, уурхай хүнд үйлдвэрийн яам нь 2021 онд үндсэн 7 зорилгын хүрээнд нийт 133 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг тайлагнасан байна. Үүнээс 92 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг бүрэн хэрэгжүүлж, 35 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг 65.0-80.0 хувтай, 6 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг 35.0-50.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Тайлант онд хөтөлбөр арга хэмжээ, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 95.9 хувийн биелэлттэй байна.

Тайлант онд гарсан мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад 2021 оны 11, 12 сард ширээний теннисний "Оч" клубын спорт заалны түрээсийн зардалд 3,235.2 мянга, БОАЖЯ-наас зохион байгуулсан "Засгийн газрын цом" тэмцээний зардалд 8,000.0 мянга, нийт 11,235.2 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал, зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөх;

3.8 Аудитын гол асуудал

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн А/104 дүгээр тушаалаар Сангийн яамнаас хэрэгжүүлж буй "Төсвийн санхүүгийн ил тод, үр ашигтай байдал" төслөөс хавсралтын 17,367.6 мянган төгрөгийн хөрөнгийг баланс аас балансад шилжүүлэн авахаар шийдвэр гарсан боловч ТӨБЗГ-аас хөрөнгө орлогод авах шийдвэр гараагүй тул бүртгэлд тусгаагүй байна.

Мөн ТӨБЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 18 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох 4 нэрийн нийт 579,304.7 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг 273,000.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосныг дараагийн тайлант хугацаанд бүртгэлд тусгахаар хүлээгдэж байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Уул, уурхай хүнд үйлдвэрийн яам шилэнд дансны нэгдсэн системд нийт 252 мэдээлэл оруулахаас 244 мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулж, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ширээний теннисний "Оч" клубын спорт заалны түрээсийн зардалд 3,235.2 мянга, "Засгийн газрын цом" тэмцээний зардалд 8,000.0 мянга, нийт 11,235.2 мянган төгрөгийг зарцуулсан нь Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.6 заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгсөн 468,348.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 10,500.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн биелэлт 80.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	468,348.4	1	155,937.9	1	310,410.5	50.0
Зөвлөмж	3	10,500.0	3	10,500.0	-	-	100.0
Нийт дүн	3	478,800.0	4	166,437.9	1	310,410.5	80.0

Өмнөх аудитаар өгсөн Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг холбогдох журамд заасан хувиар олгож байх албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд 39,400.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны буюу төсвийн шууд захирагчийн 2021 оны төсвийн төсөлд төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарал бүхий геологи, хайгуул, судалгааны 36,388,909.5 мянган төгрөгийн, хөрөнгө оруулалтын 7,694,098.2 мянган төгрөгийн зардлыг нийлүүлэн тооцоолж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн төсөвт ТЕЗ-ийн хөрөнгийн, геологи, хайгуул, судалгааны зардлыг оруулан төлөвлөсөн боловч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тус бүрд нь тайлагнаж байна.

Иймд дараагийн аудитаар тус яамны болон хөрөнгө оруулалт, геологи, хайгуул, судалгааны зардлын төлөвлөлтийн үйл явцыг төсвийн тухай хууль, холбогдох журамтай хэрхэн нийцэж байгаа эсэхийг авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 50,635.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 39,400.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 11,235.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Төлбөрийн акт

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/110 дугаар тушаалаар нэр бүхий 79 ажилтанд гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгохдоо Засгийн газрын тогтоолд заасан хувь, хэмжээнээс хэтрүүлэн 35.0-40.0 хувиар тооцон 39,400.0 мянган төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40.0 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын тогтоолд заасан хувь, хэмжээнээс хэтрүүлэн олгосон урамшууллыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс								
					Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж		
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар															
1	УУХҮЯ	АХГ-2022/220/НА-СТА-ТШЗ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/110 дугаар тушаалаар нэр бүхий 79 ажилтанд гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгохдоо Засгийн газрын тогтоолд заасан хувь, хэмжээнээс хэтрүүлэн 35.0-40.0 хувиар буюу 39,400.0 мянган төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ.	Ажилтнуудад шагнал, урамшуулал олгохдоо Засгийн газрын тогтоолд заасан хувь, хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх,	1	39,400.0			1	39,400.0					
			Дүн		1	39,400.0			1	39,400.0					
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал															
1	УУХҮЯ	АХГ-2022/220/НА-СТА-ТШЗ	Тус яамны тайлант онд гарсан мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад 2021 оны 11,12 сард ширээний теннисний "Оч" клубын спорт заалны түрээсийн зардалд 3,235.2 мянган, БОАЖЯ-наас зохион байгуулсан "Засгийн газрын цом" тэмцээний хураамж, тэмцээний зардалд 8,000.0 мянган, нийт 11,235.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.	Цаашид хууль тогтоомжид заасны дагуу спортын арга хэмжээнд хөрөнгө зарцуулах,	1	11,235.2							1	11,235.2	
			Дүн		1	11,235.2								1	11,235.2
			НИЙТ		2	50,635.2			1	39,400.0				1	11,235.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 26/А0150053
АХГ-2022/220/НА-СТБ-ТЦЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/110 дугаар тушаалаар нэр бүхий 79 ажилтанд гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн урамшуулал олгохдоо Засгийн газрын тогтоолд заасан хувь, хэмжээнээс хэтрүүлэн 35.0-40.0 хувиар буюу 39,400,000.00 төгрөгийг илүү олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2 "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40.0 хувиас хэтрэхгүй байна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Илүү олгосон 39,400,000.00 /Гучин есөн сая дөрвөн зуун мянга/ төгрөгийг холбогдох ажилтнуудаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Төлбөрийн актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ахлах нягтлан бодогч Б.Ганчимэг нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР:
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

(Handwritten signatures and initials)

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Ц.ЦЭРЭНХҮҮ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0225 Auditin 2 Gazar-19.Docx

001090073



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 168/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/220/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гарсан мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг түүвэрлэн шалгахад 2021 оны 11, 12 дугаар сард ширээний теннисний "Оч" клубын спорт заалны түрээсийн зардалд 3,235,200.00 төгрөг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан "Засгийн газрын цом" тэмцээний зардалд 8,000,000.00 төгрөг, нийт 11,235,200.00 төгрөгийг зарцуулсан байна.


Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал, зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Ахлах нягтлан бодогч Б.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЕРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ
Д ЭНХДАЛАЙ
Ц ЦЭРЭНХҮҮ

